

**УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААН ХАНГАМЖИЙН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ”-  
ИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЖУРАМ, ДЭЛХИЙН БАНКНЫ СТАНДАРТ ШААРДЛАГЫГ  
ХАНГАЖ АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ  
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ**

**ОРОЛЦОХ СОНИРХЛОО ИЛЭРХИЙЛЭХ УРИЛГА  
(ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ - КОМПАНИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ)**

Огноо: 2024 оны 03 дугаар сарын 04

**Монгол Улс**

Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл

Зээлийн дугаар :6589 MN

**Даалгаврын нэр:** “Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл”-ийн Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээний үйл ажиллагаанд Монгол Улсын хууль журам, Дэлхийн банкны стандарт шаардлагыг хангаж ажиллах төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөх үйлчилгээ”

**Дугаар:** CS-ESM-19

Эрчим хүчний яам нь Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөлд зориулан Дэлхийн банкнаас санхүүжилт хүлээн авсан бөгөөд санхүүжилтийн тодорхой хэсгийг зөвлөх үйлчилгээнд ашиглана.

Зөвлөх үйлчилгээ (“Үйлчилгээ”) нь Дулааны шугам өргөтгөх шинэчлэх төслийн ажлын аливаа үйл ажиллагаа нь Дэлхийн банк болон Үндэсний хууль тогтоомжийн дагуу байгаль орчин ба нийгмийн хүрээнд байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл, нөлөөллөөс зайлсхийх, багасгах зорилгоор боловсруулсан байгаль орчин нийгмийн хууль журам стандартыг баримтлан ажиллах шаардлагад хяналт тавих ажлуудаас бүрдэнэ.

Эрчим хүчний яам нь эрх бүхий зөвлөх компаниудыг Зөвлөх үйлчилгээ үзүүлэх сонирхолоо илэрхийлэхийг урьж байна. Сонирхсон зөвлөхүүд нь үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах шаардлага, туршлагатай болохыг нотолсон мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

**1. БОН-ийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх компаниудад тавигдах мэргэшлийн хамгийн бага шаардлага. Үүнд:**

- 1.1 БОАЖЯ-ны байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх эрхтэй байх;
- 1.2 Байгаль орчин, нийгмийн хүрээний нарийвчилсан үнэлгээ хийж байсан 3 аас дээш жилийн туршлагатай байх;
- 1.3 Байгаль орчин, нийгмийн нарийвчилсан үнэлгээ хийж төлөвлөгөө боловсруулж байсан 2-оос доошгүй ажлын жагсаалт (гэрээ, хүлээлгэн өгсөн акт баримтын хуулбарыг хавсаргах);
- 1.4 2020, 2021, 2022 онуудын аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангын хуулбар ирүүлнэ;

1.5 Агаар ,хөрс, дуу чимээ усны бохирдлыг хэмжих хэмжилт, судалгааны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх;

## **2. Зөвлөх компанийн гол мэргэжилтэн, шинжээчид тавигдах шаардлага**

2.1 Байгалийн шинжлэх ухаан болон байгаль орчны инженерчлэлийн чиглэлээр бакалавр ба түүнээс дээш түвшний боловсролын зэрэгтэй байх;

2.2 Байгаль орчин мониторинг, хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр гурваас доошгүй жилийн ажлын туршлагатай байх;

2.3 Харилцааны өндөр ур чадвартай;

2.4 Англи, монгол хэлээр тайлан бичих, бичиг баримт боловсруулах, хянах ур чадвартай байх;

2.5 Оффисын хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай байх;

Сонирхсон зөвлөхүүд Дэлхийн Банкны Зээлдэгч нарт зориулсан худалдан авах ажиллагааны журам, (2016 оны 7 дугаар сар, 2020 оны 11 дүгээр сард шинэчилсэн) журамд тодорхойлсон Дэлхийн Банкны ашиг сонирхлын зөрчлийн талаарх бодлогод нийцсэн байх. Мөн энэхүү даалгавартай холбоотой ашиг сонирхлын зөрчлийн талаархи дээрх журмын 3.14 болон 3.17 (b)(c)(d) заалтуудыг үзнэ үү.

Зөвлөх компани нь чадвараа сайжруулахын тулд бусад компанитай түншлэлийн хэлбэрээр оролцож болно. Хэрэв түншлэлээр хэрэгжүүлэх бол хариуцлагыг хамтран хариуцна.

Худалдан авах ажиллагааны журамд заасны дагуу зөвлөхийн чадварын үнэлгээний аргаар сонгон шалгаруулна.

Нэмэлт мэдээллийг ажлын өдөр 09:00-17:00 цагийн хооронд доорх хаягаар ирж авна уу.

Сонирхлоо илэрхийлсэн баримт бичгийг 2024 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн 11:00 цаг хүртэл доорх хаягаар ирүүлнэ. Цахимаар материал хүлээн авахгүй.

### **Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хаяг:**

*Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо Үйлдвэрчний гудамж,  
Комфорт плаза 10 давхар 1003 тоот*

*Эрчим хүчний яамны Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг  
нэмгдүүлэх төсөл*

*Төсөл хэрэгжүүлэх нэгжийн Байгаль, орчин нийгмийн ажилтан Б.Азжаргал  
Утас:+976-77006589; 95808998, И-мэйл: [bnazjargal@gmail.com](mailto:bnazjargal@gmail.com)*